

Ерөнхий тайлбар No. 22: 18-р зүйл (Бодож сэтгэх, сүслэн бишрэх, шашин шүтэх эрх чөлөө)

1993 оны долдугаар сарын 30-нд Хүний эрхийн Комиссын 48 дугаар зөвлөгөнөөр батлагдсан

1. 18.1-д заасан бодож сэтгэх, сүслэн бишрэх, шашин шүтэх эрх чөлөө (үүнд итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө багтана) нь өргөн цар хүрээтэй бөгөөд гүн гүнзгий юм. Энэ нь бүх асуудлаар, ганцаар эсхүл бусадтай хамтран өөрийн итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх эсхүл итгэж үнэмших шийдвэр гаргах бодож сэтгэх эрх чөлөөг агуулдаг. Хороо нь бодож сэтгэх эрх чөлөө, сүслэн бишрэх эрх чөлөө нь шашин шүтэх, итгэн үнэмших эрх чөлөөтэй эрх тэгш хамгаалагддаг болохыг оролцогч улсуудад анхааруулдаг. Эдгээр эрх чөлөөнүүдийн үндсэн мөн чанар нь, Пактын 4 дүгээр зүйлийн 2 дугаарт заасанчлан, ямар ч үед, олон нийтийн онцгой байдлын үед ч гэсэн, энэхүү заалтыг үл тоомсорлож болохгүй гэдгээр илт тодорхойлогддог.

2. 18-р зүйлд шашинлаг, шашингүй, шашины эсрэг итгэл үнэмшлийг хамгаалахаас гадна аливаа шашин үл шүтэх, үл итгэж үнэмших эрхийг хамгаалдаг. Итгэл үнэмшил ба шашин шүтлэг гэсэн нэр томъёонуудыг өргөн хүрээнд тайлбарлах шаардлагатай. 18 дугаар зүйл нь хэрэглээний хувьд уламжлалт шашин, байгууллагын шинж чанартай эсхүл уламжлалт шашны шинжийг өөртөө агуулсан зан үйлсээр илэрхийлэгддэг шашин эсхүл итгэл үнэмшилтэй шашин болоод итгэл үнэмшлүүдээр хязгаарлагддаггүй. Иймд, Хороо аливаа шашин шүтлэг, итгэл үнэмшлийг ямар нэг шалтгаанаар, тухайлбал, шинээр байгуулагдсан, эсхүл шашны олонх бүхий орон нутгийнхны дайсагналыг өдөөх сэдэл болох магадлал бүхий шашны цөөнхийн төлөөлөл, гэх мэтийг харгалзан үзсэний үндсэн дээр, аливаа шашин, итгэл үнэмшлийн улмаас ялгаварлан гадуурхах хандлагыг анхааралтай ажиглагддаг.

3. 18-р зүйл нь бодож сэтгэх, сүслэн бишрэх, шашин шүтэх, итгэн үнэмших эрх чөлөөг шашин шүтлэг, итгэл үнэмшлээ номлох эрх чөлөөнөөс ангид авч үздэг. Энэ нь бодож сэтгэх, сүслэн бишрэх, эсхүл өөрийн сонгосон шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй болох, түүнийг дагаж мөрдөх эрх чөлөөг хязгаарлахыг зөвшөөрдөггүй. Эдгээр эрх чөлөө нь ямар ч болзолгүйгээр хамгаалагдсан бөгөөд 19.1-р зүйлд заасанчлан хөндлөнгийн оролцоогүйгээр хүн бүр санал бодлоо илэрхийлэх эрх нь мөн адил хамгаалагдсан. 18.2 болон 17 дугаар зүйлүүдэд заасны дагуу, хэнийг ч өөрийн бодол санаагаа илэрхийлэх, аливаа шашин эсхүл итгэл үнэмшил даган мөрдөхийг албадах ёсгүй.

4. Шашин шүтлэг, итгэл үнэмшлээ номлох эрх чөлөөг “ганцаараа эсхүл орон нутагтаа бусдын хамтаар, эсхүл олон нийтийн газар, хувийн орон зайдаа” эдэлж болно. Шашны мөргөл үйлдэх, заншил гүйцэтгэх, уламжлалт зан үйл үйлдэх болон сургах үед шашин шүтлэг, итгэл үнэмшлээ номлох эрх чөлөө нь олон төрлийн зан үйлийг багтаадаг. Мөргөл хэмээх ойлголт нь итгэл үнэмшлийг шууд илэрхийлэх зан үйл, ёслолын үйл ажиллагаа, түүнчлэн эдгээр үйл ажиллагаатай салшгүй холбоотой янз бүрийн зан үйл, тухайлбал, мөргөлийн газар барих,

ёслолын нэр томъёо, эд зүйл ашиглах, бэлгэдлийг харуулах, сахих үйл ажиллагаануудыг багтаадаг бөгөөд баярын болон амралтын өдрүүдээр гүйцэтгэдэг заншлууд ч бас үүнд ордог. Шашин шүтэх, эсхүл итгэл үнэмшлээ сахих, хэрэгжүүлэх ойлголтод дан ганц ёслолын үйл ажиллагаа бус хоолны дэглэм сахих, өвөрмөц хувцас өмсөх, нүүрээ халхлах, амьдралын тодорхой үе шатуудтай холбоотой зан үйлд оролцох болон тодорхой хэсэг бүлэг хүмүүсийн хэрэглэдэг хэл яриа зэрэг ёс заншлыг багтааж болно. Үүнээс гадна, шашин шүтлэг, итгэл үнэмшлээ хэрэгжүүлэх, сургах ойлголтод шашны удирдагчид, санваартнууд, багш нараа сонгох эрх чөлөө, семинар, шашны сургууль байгуулах эрх чөлөө, шашны сурах бичиг, хэвлэгдэхүүн бэлтгэх, тараах эрх чөлөө зэрэг шашны бүлгийн салшгүй нэг хэсэг болсон үйлдлүүдийг багтаадаг.

5. Хороо нь аливаа шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх, болох эрх нь шашин шүтлэг, итгэл үнэмшлээ сонгох эрх чөлөө, түүний дотор одоогийн шашин шүтлэг, итгэл үнэмшлээ өөр шашинаар солих, эсхүл шашины эсрэг үзэл бодлоо хүлээн авах, түүнчлэн өөрийн шашин шүтлэг, итгэл үнэмшлээ хамгаалах эрх зэргийг агуулдаг болохыг чанд сахидаг. 18.2 нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх, болох эрх чөлөөг хязгаарлаж болохуйц, үүн дотор, бие махбодид хүчээр заналхийлэх, эсхүл итгэгчдийг болон үл итгэгчдийг өөрсдийнхөө шашны цуглаан болон шашны итгэл үнэмшилд дагуулах, тэдний шашин шүтлэг, итгэл үнэмшлийг няцаах, эсхүл хувиргах зорилгоор тулгах зэрэг албан шаардлагуудад эрүүгийн шийтгэл ноогдуулахад хориг тавьдаг. Боловсрол, эмнэлгийн тусламж, ажил эрхлэлт буюу 25 дугаар зүйлээр болоод Пактын бусад заалтуудаар хамгаалагдсан эрхүүдийг хязгаарлаж буй ижил зорилго, үр нөлөө бүхий бодлого, уламжлалт ажиллагаанууд ч бас 18.2 дугаар зүйлтэй нийцдэггүй. Шашны бус мөн чанар бүхий бүх итгэл үнэмшилтэй хүмүүс ч мөн адил ижил хамгаалалт эдэлдэг.

6. 18.4 дүгээр зүйл нь шашны, ёс суртахууны ерөнхий түүх зэрэг хичээлүүдийг улсын сургуульд төвийн сахисан байдлаар, мөн зорилготойгоор заахыг зөвшөөрдгийг Хороо анхааралдаа авдаг. 18.4-т заасан шашны болон ёс суртахууны хүмүүжлийг хүүхдүүддээ өөрсдийн итгэл үнэмшлийн дагуу олгохын тулд эцэг эх, хууль ёсны төлөөлөгчдийн эрх чөлөө нь 18.1-д заасан шашин шүтлэг, итгэл үнэмшлийг заан сургах эрх чөлөөний баталгаажуулахтай холбоотой байдаг. Хорооны тэмдэглэсэнчлэн, тодорхой шашин шүтлэг, итгэл үнэмшлийн талаарх сургаалыг багтаасан олон нийтийн боловсрол нь эцэг эх, асран хамгаалагчдын хүсэл сонирхлыг харгалзан үзэж, ялгаварлан гадуурхахгүйгээр чөлөөлөх, эсхүл өөр хувилбараар хангахгүй бол энэ нь 18.4 дүгээр зүйлтэй зөрчилдөнө.

7. 20 дугаар зүйлд заасны дагуу, шашин шүтлэг, итгэл үнэмшлээ номлохыг ялгаварлан гадуурхах, дайсагнал, хүчирхийллийг өдөөх, дайныг сурталчлах, үндэсний, арьс өнгө, шашны үзэн ядалтыг сурталчлахтай адилтгаж болохгүй. Хорооноос гаргасан 11 дүгээр Ерөнхий тайлбарт дурдсанчлан, оролцогч улсууд ийм үйлдлийг хориглох хууль батлах үүрэгтэй.

8. 18.3 дугаар зүйл нь шашин шүтлэг, итгэл үнэмшлээ номлох эрх чөлөөнд хориг тавихыг зөвшөөрдөг бөгөөд энэ нь зөвхөн тэдгээр хориг нь хуулийн хүрээнд, мөн нийтийн аюулгүй байдал, дэг журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад шаардлагатай тохиолдолд л хүчинтэй. Шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй байх, болох албадлагаас ангид байх, эцэг эх, асран хамгаалагчдын шашны болон ёс суртахууны боловсролтой байх эрх чөлөөг хязгаарлаж болохгүй. Зөвшөөрөгдөх хязгаарлалт, хоригуудын заалтуудын хамрах хүрээг ойлгохдоо, оролцогч улсууд Пактаар баталгаажсан эрхээ хамгаалах, түүний дотор 2, 3, 26 дугаар зүйлүүдэд заасан бүх үндэслэлээр тэгш байдал, ялгаварлан

гадуурхахгүй байх эрхийг хамгаалах хэрэгцээнээс эхлэх нь зүйтэй. Ноогдуулсан хязгаарлалтууд нь хуулийн дагуу тогтоосон байх ёстойн сацуу 18 дугаар зүйлд заасан баталгаатай эрхүүдийг хүчингүй болгох байдлаар хэрэглэгдэхгүй байх ёстой. Хорооноос сануулж байгаачлан, 18 дугаар зүйлийн 3 дахь догол мөрийг чанд хатуу ойлгох ёстой: үндэсний аюулгүй байдал зэрэг Пактаар хамгаалагдсан бусад эрхийг хязгаарлахыг зөвшөөрсөн хэдий ч тэнд заагаагүй үндэслэлээр хязгаарлалт хийхийг хориглоно. Хязгаарлалтыг зөвхөн тогтоосон зорилгод нь хамааруулж тавьж болох бөгөөд тэдгээр нь урьдчилан тодорхойлсон, тодорхой хэрэгцээтэй шууд хамааралтай, мөн зохистой байх ёстой. Ялгаварлан гадуурхах зорилгоор хязгаарлалт тогтоож, ялгаварлан гадуурхах замаар мөн хэрэгжүүлж болохгүй. Ёс суртахуун хэмээх ухагдахуун нь нийгэм, философи, шашны олон уламжлалаас гаралтай болохыг Хороо сануулдаг. Улмаар, ёс суртахууныг хамгаалах зорилгоор шашин шүтлэг, итгэл үнэмшлээ номлох эрх чөлөөнд хязгаарлалт тавих нь дан ганц нэг уламжлалаас үүдэлтэй бус зарчмуудад суурилсан байх ёстой. Хоригдлууд гэх мэт хууль ёсны хязгаарлалтад өртсөн хүмүүс тухайн хууль ёсны хязгаарлалтын өвөрмөц онцлогтой нийцсэн шашин шүтлэг, итгэл үнэмшлээ номлох эрх чөлөөг бүрэн эдлэх нь зүйтэй. Оролцогч улсуудын тайланд 18.3-т заасан хязгаарлалтуудын бүрэн хамрах хүрээ, үр дагаврын талаархи мэдээллийг, хууль тогтоомжийн дагуу болон тодорхой нөхцөл дэх хэрэглээний хүрээнд, тусгах ёстой.

9. Шашин шүтлэгийг төрийн гэж хүлээн зөвшөөрсөн, эсхүл албан ёсны буюу уламжлалт, эсхүл хүн амын дийлэнх нь тухайн шашин шүтлэгийг мөрддөг байх нь Пактын дагуу, үүн дотор 18 болон 27 дугаар зүйлүүдийн, олгогдсон эрхүүдийн аль нэгийг доройтуулахгүй байх, эсхүл бусад шашныг дагагчдын болоод үл итгэгчдийн эсрэг аливаа ялгаварлан гадуурхалд хүргэхгүй байх нь зүйтэй. Тодруулбал, үл итгэгчдийг ялгаварлан гадуурхах зарим, тухайлбал, шашны олонхи болох гишүүдийн төрийн албанд хамрагдах эрхийг хязгаарлах, эсхүл тэдэнд эдийн засгийн давуу эрх олгох, эсхүл бусад итгэл үнэмшлээ хэрэгжүүлэхэд тусгай хориг тавих зэрэг арга хэмжээнүүд нь 26 дугаар зүйлд заасан эрх тэгш хамгаалалтын баталгаа болон шашин шүтлэг, эсхүл итгэл үнэмшилд суурилсан ялгаварлан гадуурхлыг хориглодогтой үл нийцдэг. Пактын 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан арга хэмжээнүүд нь шашны цөөнх болон бусад шашны бүлгүүдийн 18, 27 дугаар зүйлд заасан баталгаатай эрхийг хэрэгжүүлэх эрхийг зөрчих, тэдгээр бүлгүүдэд чиглэсэн хүчирхийлэл, хавчлагаас хамгаалах чухал хамгаалалтыг бүрдүүлдэг. Бүх шашин шүтлэг, итгэл үнэмшлийн зан үйлийн зөрчлөөс хамгаалах, дагалдагчдаа ялгаварлан гадуурхахаас хамгаалах талаар холбогдох оролцогч улсуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Хороонд мэдээлэхийг хүсдэг. Үүний нэгэн адил, 27 дугаар зүйлд заасны дагуу, шашны цөөнхийн эрхийг хүндэтгэх талаарх мэдээлэл нь Хорооноос оролцогч улсуудын үзэл бодлын, ухамсрын, шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй байх эрхийн хэрэгжилтийн түвшинг үнэлэхэд шаардлагатай. Холбогдох оролцогч улсууд нь өөрсдийн хууль, тогтоомжинд заасны дагуу гүтгэсэн хэмээн шийтгэгдэхүйц туршлагатай холбогдох мэдээллийг тайландаа оруулах нь зүйтэй.

10. Хэрэв итгэл үнэмшлийн багцыг үндсэн хууль, дүрэм, эрх баригч намуудын тунхаглал гэх мэт албан ёсны үзэл суртал гэж үзвэл, 18 дугаар зүйлд заасны дагуу эрх чөлөө, эсхүл Пактаар хүлээн зөвшөөрөгдсөн бусад эрхийг доройтуулахгүй, түүнчлэн албан ёсны үзэл сурталыг хүлээн зөвшөөрдөггүй, эсхүл түүнийг эсэргүүцдэг хүмүүсийг ялгаварлан гадуурхалд өртүүлэхгүй байх нь зүйтэй.

11. 18 дугаар зүйлд заасан тэдний эрх чөлөөнөөс үүдэлтэй гэж үзсэний үндсэн дээр олон хувь хүмүүс цэргийн албанаас татгалзах (сүсэг бишрэлийн улмаас эсэргүүцэх) эрхээ нэхэмжилдэг. Ийм нэхэмжлэлийн хариуд, хууль тогтоомжийнхоо дагуу цэргийн алба хаахыг

хориглосон шашны болон бусад итгэл үнэмшилтэй иргэдийг цэргийн алба заавал хаах үүргээс чөлөөлөх, өөр хэлбэрээр үндэсний алба хаах арга хэмжээ авах улс орнуудын тоо ихэсч байна. Пактад сүсэг бишрэлийн улмаас эсэргүүцэх эрхийн талаар тодорхой заагаагүй ч Хорооны үзэж байгаагаар, үхлийн хүч хэрэглэх үүрэг нь сүслэн бишрэх эрх чөлөө, шашин шүтлэг, итгэл үнэмшлээ номлох эрхүүдтэй ноцтойгоор зөрчилдөж болох учраас сүслэн бишрэх эрхийг 18 дугаар зүйлээс авч болох юм. Энэхүү эрх нь хуулиар баталгаажсан, эсхүл амьдралд хүлээн зөвшөөрөгдсөн үед тодорхой итгэл үнэмшлийн мөн чанараас улбаалсан ангилал сүслэн бишрэгч эсэргүүцэгчдийн дунд байдаггүй. Үүний нэгэн адил, цэргийн алба хаагаагүйн улмаас сүслэн бишрэгч эсэргүүцэгчдийн эсрэг ялгаварлан гадуурхал байх ёсгүй. Хороо нь оролцогч улсуудыг 18 дугаар зүйлд заасан эрхийнхээ дагуу цэргийн албанаас чөлөөлөгдөх нөхцлүүд болон өөр хэлбэрээр үндэсний алба хаах мөн чанар болон хугацааны талаар тайлагнахыг хүсдэг.